



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний аудитын газрын албан ажлын хэрэгцээнд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалт, 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 3 ширхэг автомашин олж авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга Ц.Ганболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



000260

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
198 дугаар тогтоолын хавсралт



Үндэсний аудитын газрын олж авах автомашины
техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар

Д/д	Хөрөнгийн нэр	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо ширхэг	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Суудлын, хөдөлгүүрийн багтаамж 4500 cc хүртэл, суудлын тоо 7	120,000,000.00	3	360,000,000.00
	Нийт дүн		3	360,000,000.00 /гурван зуун жаран сая/